



**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТЫН  
ЗӨВЛӨЛ, ЧИГ ҮҮРГИЙН ХОРОО, ХОЛБООНООС БАЙГУУЛСАН  
КОМИССЫН ГИШҮҮНД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Улаанбаатар хот  
2013 он**

## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.9.3 дахь заалт, 52 дугаар зүйлийн 52.8 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Монголын Хуульчдын холбооны зөвлөл, хяналтын зөвлөл, чиг үүргийн хороо, холбооноос байгуулсан комиссын гишүүнд урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ,  
ЧИГ ҮҮРГИЙН ХОРОО, ХОЛБООНООС БАЙГУУЛСАН КОМИССЫН  
ГИШҮҮНД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1.1 дүгээр зүйл.Ерөнхий зүйл**

1.Энэ журмын зорилго нь Хуульчдын холбооны зөвлөл, хяналтын зөвлөл, чиг үүргийн хороо, комиссын гишүүн /цаашид “Гишүүн” гэх/-д урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монголын Хуульчдын холбооны холбогдох дүрэм, журмыг үндэслэн гишүүнд мөнгөн урамшуулал олгоход энэ журмыг баримтална.

3.Энэ журамд хэрэглэгдэх дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.“Комисс” гэж Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан комиссыг;

3.2.“хуралдаан, үйл ажиллагаа” гэж Хуульчдын холбооны зөвлөл, хяналтын зөвлөл, чиг үүргийн хороо, комиссын гишүүний оролцсон хуралдаан болон бусад үйл ажиллагааг.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
УРАМШУУЛАЛ ОЛГОХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ҮНДЭСЛЭЛ,  
УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ**

**2.1 дүгээр зүйл.Урамшуулал олгох зарчим**

1.Гишүүнд урамшуулал олгохдоо дараах зарчмыг баримтална:

- 1.1.шударга байх;
- 1.2.гишүүний идэвх, санаачлага, оролцоонд үндэслэсэн байх;
- 1.3.гишүүдэд эрх тэгш хандах;
- 1.4.ил тод байх;
- 1.5.Хуульчдын холбооноос баталсан дүрэм, журамд нийцсэн байх.

**2.2 дугаар зүйл.Урамшуулал олгох**

1.Гишүүнд урамшууллыг дараах үндэслэлээр олгоно:

- 1.1.хуралдаан, үйл ажиллагааны ирц;
- 1.2.хуралдаан, үйл ажиллагаанд оролцсон байдал, ажлын гүйцэтгэл.

2.Гишүүнд олгох урамшууллын хэмжээг тогтоохдоо Хуульчдын холбооны зөвлөл, хяналтын зөвлөл, чиг үүргийн хороо, комиссын хуралдааны тоо, үйл ажиллагаанд зарцуулагдах цаг, үр дүнг харгалзана.

**2.3 дугаар зүйл.Хуралдаан, үйл ажиллагааны ирц, түүний бүртгэл**

1.Гишүүн хуралдаан, үйл ажиллагаанд оролцсон байдлыг батлагдсан маягтын дагуу хөтөлсөн бүртгэлийн хуудас болон урьдчилан бичгээр өгсөн саналыг үндэслэж,

Хуульчдын холбооны зөвлөлийн хурал даргалагч, хяналтын зөвлөл, чиг үүргийн хороо, комиссын дарга баталгаажуулснаар урамшуулал олгох үндэслэл бүрдэнэ.

2.Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцвол зохих хуралдаан, үйл ажиллагаанд биечлэн оролцоогүй боловч холбогдох асуудал бүрд өөрийн саналыг урьдчилан бичгээр өгсөн тохиолдолд түүнийг тухайн хуралдаан, үйл ажиллагаанд оролцсонд тооцож, олговол зохих урамшууллын 30 хүртэлх хувийг олгоно.

3.Энэ зүйлийн 2-т заасан баримтыг ирүүлээгүй бол гишүүнийг тухайн хуралдаан, үйл ажиллагааг тасалсанд тооцож, урамшууллыг олгохгүй.

4.Гишүүн нь хуралдаан, үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаан, үйл ажиллагаанд бүтэн оролцох боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд оролцсон цагт нь тохирсон урамшууллыг олгоно.

#### **2.4 дүгээр зүйл. Урамшууллын хэмжээ, олгох хугацаа**

1.Хяналтын зөвлөлийн гишүүний урамшууллыг Монголын Хуульчдын холбооны дүрмийн 7.7 дугаар зүйлийн 1-д зааснаар Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, бусад нэгжийн гишүүнд олгох урамшууллын хэмжээг Хуульчдын холбооны зөвлөл тогтооно.

2.Хуульчдын холбооны зөвлөл, хяналтын зөвлөл, чиг үүргийн хороо, комиссын гишүүнд олгох урамшууллыг цагаар тооцно.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

3.Гишүүнд урамшуулал олгох хугацааг тухайн гишүүний ажиллаж буй хуралдаан, үйл ажиллагааны тов, онцлог болон ажлын ачааллыг харгалзан дараах байдлаар тогтооно:

3.1.Хуульчдын холбооны зөвлөлийн гишүүдэд урамшууллыг улиралд нэг удаа;

[/Энэ заалтад Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

3.2.хяналтын зөвлөлийн гишүүдэд урамшууллыг жилд нэг удаа;

3.3.чиг үүргийн хорооны гишүүдэд урамшууллыг улиралд нэг удаа;

3.4.комиссын гишүүдээс ажлын тайлан хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Хуульчдын холбооны Тамгын газар нь гишүүн бүрийн оролцсон хуралдаан, үйл ажиллагааны тайланг харгалзан урамшууллыг олгоно.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **3.1 дүгээр зүйл.Журам хүчин төгөлдөр болох**

1.Энэ журмыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.